

БАТЛАВ.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮРӨРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ЭНХ-ЭРДЭНЭ

**“ТАНД ОЙРХОН ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ” НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ  
ӨДӨРЛӨГ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ**

**Нэг. Зорилго:**

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ойртуулж төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх, салбарын бодлого, чиглэл, үйл ажиллагаа, хууль, эрх зүйг сурталчлан таниулах, мэдээ, мэдээлэл, зөвлөмж, зөвлөгөө өгөх, санал, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн төр, иргэний хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

**Хоёр. Зорилт:**

Улсын бүртгэлийн хэлтсээс төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор аймгийн оршин суугч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх;

Иргэдийн санал хүсэлтийг сонсох, тулгамдаж буй асуудлыг тухай бүр түргэн, шуурхай шийдвэрлэх;

Бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж иргэд олон нийтэд цогц үйлчилгээ үзүүлэх;

Улсын бүртгэлийн түүхэн баримт бичгийн үзэсгэлэнг олон нийтэд үзүүлэх;

**Гурав. Хамрах хүрээ:**

Дорноговь аймгийн иргэд, олон нийтэд;

**Дөрөв. Зохион байгуулагч:**

Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

**Тав. Оролцогч байгууллага:**

Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

**Зургаа. Хугацаа, байршил:**

2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 11:00–16:00 цагт Соёмбо цогцолборын урд талбайд зохион байгуулагдана.

**Долоо: Арга хэмжээ:**

Улсын бүртгэлийн дараах лавлагаа, үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг хүргэн ажиллах юм. Үүнд:

Захиалгын үйлчилгээ үзүүлэх:

- Иргэний үнэмлэхийн захиалга авах;
- Хэвлэгдэж ирсэн үнэмлэхийг олгох;
- Гадаад паспортын захиалга авах;
- Хэвлэгдэж ирсэн паспортыг олгох;

Шууд үйлчилгээ үзүүлэх:

- Үл хөдлөх, эд хөрөнгө шинээр бүртгүүлэх, гэрээ (барьцааны гэрээний бүртгэл, худалдах, худалдан авах, бэлэглэх, өвлөх эрхийн)-ний үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлийг тухай бүр гүйцэтгэх;
- Өмчлөлийн газрыг шинээр бүртгэх, гэрээ (барьцааны гэрээний бүртгэл, худалдах, худалдан авах, бэлэглэх, өвлөх эрхийн)-ний үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлийг тухай бүр гүйцэтгэх;
- Шинээр хуулийн этгээд бүртгүүлэх;
- Хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах;
- Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт хийх;
- Шинээр төрсний бүртгэл, гэрлэсний бүртгэл, гэрлэлт цуцлуулсан бүртгэл, үрчлэлт, эцэг тогтоолгох, овог нэр өөрчлөлт, нас барсны бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг тухай бүр гүйцэтгэх;
- Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчлийг тухай бүр хянан шийдвэрлэх;
- Иргэдэд тоон гарын үсгийг сурталчилан таниулах;
- Тоон гарын үсгийг үнэ төлбөргүй олгох;
- Улсын бүртгэлийн лавлагaa үйлчилгээ (Бүх төрлөөр);
- Улсын бүртгэлийн байгууллагын цахим үйлчилгээний талаарх зөвлөгөө, мэдээлэл өгөх;
- Хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэл ханамжийн судалгаа авах;
- Иргэдийн санал хүсэлтийг сонсож, шийдвэрлэх;

#### **Найм. Оролцогч байгууллагын үйлчилгээ**

- Газарт холбоотой үйл ажиллагааг цаг тухайд хүргэх;
- Цахим шилжилтийн талаарх мэдээ, мэдээллийг түгээх;
- Хууль, эрх зүйн орчны сурталчлан таниулах, мэдээ, мэдээлэл өгөх;
- Бусад;

#### **Ес. Тайлагнах**

Тус арга хэмжээг зохион байгуулсан тухай илтгэх хуудас, иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийг нэгтгэн удирдамжийн дагуу Хэлтсийн даргад тайлagnана.

Нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаанаас гарсан үр дүнг Улсын бүртгэлийн ерөнхий газар болон аймгийн Засаг даргад хүргүүлэх.

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**